

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт:

“2.1.3.”эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.10.в-д заасныг;”

2/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

“3.4.“Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалтыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийн “хуулийн 5.1.1-д заасан” гэснийг “хуульд заасан өндөр насны тэтгэврийн ердийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 14.2, 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн тус тус “протез” гэснийг “эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ